



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхлагчдын өргөн чөлөө I-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс: 7034-2580  
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.02.24 № 187

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

Г БҮРЭГХАНГАЙ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Н.ЖАРГАЛСАЙХАН  
ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүрэгхангай сумын ЕБС-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бүрэгхангай ЕБС-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

**Аудитын гол асуудал**

Өмнөх онд "Мэксим консалтинг" ХХК-тай 48 сарын хугацаатай байгуулсан ерөнхий гэрээний дагуу тайлант хугацаанд 16.1 сая төгрөг төлж, 43.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 61.7 сая, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 101.5 сая, хандиваар 66.5 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч бүртгэлд тусгасан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бүрэгхангай сумын ЕБС нь байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын 63 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжүүлснийг аймгийн Боловсролын газар 87.7 хувиар дүгнэсэн байна. Тус сургууль аймгийн ИТХ-ын 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн VII/46 дугаар тогтоолыг үндэслэн

6326050195

сургуулийн түүхэн 100 жилийн ойн баярыг тэмдэглэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

ААБ 6.8: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: Бүрэгхангай сумын ЕБС

Аудитын код: БУА-2026/134/НА-СТА-ТШЗ

Байгууллагын РД: 9011552

Аудитын нэр: Санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт А. Эрсдэлтэй АГАДҮТ-ын үнэлсэн алдаа, зөрчлийг шийдвэрлэх

Тайлант хугацаа: 2025.01.01-2025.12.31

Дд	АГАДТ	АГАДТ-ын дүл анги	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Материаллаг эсэх	Үр өгөөжөөр тооцох эсэх	Шалгуур үзүүлэлт		Алдаа зөрчлийн ангилал	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу	Гаргасан шийдэл
							Стандарт заалт	Хууль тогтоомжийн заалт					
1		МХ	Сургуулийн захирал Н.Жаргалсайханд аймгийн Боловсролын газрын 2025.10.08-ны өдрийн А/104 дүгээр тушаалыг үндэслэн батлагдаагүй орон тооны ХАБ-ын ажилтны хавсран ажилласны 40 хувийн нэмэгдэл хэлс олгосон.	654,800.00	Материаллаг	Тийм	УСНБӨУС 1	Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих, 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах. Булган аймгийн боловсролын газрын 2025.11.04-ний өдрийн А/114 дүгээр тушаалаар 2025.10.08-ны А/104 дүгээр тушаалыг хүчингүй болгосон.	Хууль тогтоомжийн заалттай холбоотой	Төлбөрийн акт тогтоох	Тайлбар ирүүлсэн	Албан шаардлага өгөх	Албан шаардлага өгөх
2		МХ	Сургуулийн захирал Н.Жаргалсайханд аймгийн Боловсролын газрын даргын 2025.09.04-ний өдрийн А/89 дугаар тушаалыг үндэслэн сургуулийн 100 жилийн ойн өргө хэмжээг амжилттай зохион байгуулж ажилласан гэх үндэслэлээр нэг сарын үндсэн шалинтай тэнцэх мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.	1,637,000.00	Материаллаг	Тийм	УСНБӨУС 1	Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих, 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.3-т "Байгууллагаас хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно."	Хууль тогтоомжийн заалттай холбоотой	Төлбөрийн акт тогтоох	Тайлбар ирүүлсэн	Төлбөрийн акт тогтоох	Төлбөрийн акт тогтоох
3		МХ	Сургуулийн нягтлан бодогч, нярав нарт Боловсролын сардын 2025.08.07-ны өдрийн 1/3492 тоот албан бичгийг үндэслэн сургуулийн захирлын тушаалаар нэг сарын үндсэн шалинтай тэнцэх мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.	2,684,000.00	Материаллаг бус	Тийм	УСНБӨУС 1	Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих, 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах.	Хууль тогтоомжийн заалттай холбоотой	Зөвлөмж өгөх		Зөвлөмж өгөх	Зөвлөмж өгөх



